

БАГШИЙН АЖЛЫН БАЙРАНДАА ХӨГЖИХ АРГА ЗАМУУД

Лхүндэвийн Цэрэннадмид
МУБИС-ийн Архангайн Багшийн сургууль
Tserennadmid.1@msue.edu.mn

Хураангуй

Нийгэм хөгжихийн хэрээр багшийн ажилд шинэ шинэ шаардлагууд тавигдаж, багш шинэ үзэл санаа, шинэ арга барилыг эрэн хайж, сурч мэдэх хэрэгтэй болж байна. Багш ажлын байран дээрээ хөгжихийн гол үндэс бол бие дааж ажиллах, идэвх чармайлт гаргах, сургууль, нийгмийн хүрээний үйл ажиллагаанд идэвх зүтгэлээр оролцох, хууль эрх зүй, нийгэм эдийн засаг, улс төрийн боловсролоо дээшлүүлэх, мэргэжлийн онол, заах арга зүйн мэдлэг ур чадвараа хөгжүүлэх, өөрийнхөө авьяас, ерөнхий соёлыг дээшлүүлэх зэрэг багшийн хувийн зүгээс анхаарах асуудлууд урган гарч ирж байгаа хэдий ч багшийн хөгжилд тулгамдсан эдгээр асуудлуудыг зөвхөн багшаас өөрөөс нь шалтгаалдаг мэтээр ойлгож болохгүй.

Учир нь багийн бага сургуулийн багш нарыг бодвол сумдын багш нар, сумдын багш нарыг бодвол аймгийн төвийн багш нар орчин үетэйгээ арай илүү ойртож, яваа юм байна гэдэг нь бидний судалгаанаас тодорхой харагдаж байна. Жишээлбэл: аймгийн төвийн багш нар интернэтийн хурд удаан гэсэн байхад сумдын багш нар интернэт байхгүй гэсэн байна. Харин багийн бага сургуулийн багш нар бүр гэрэл, цахилгаан байхгүй гэж судалгаанд хариулжээ.

Багшийг мэргэжлээрээ бүтээлч тасралтгүй ажиллахад бүх хүч нөөцөө сургалтын ажилдаа зориулахад нь эдийн засаг, нийгмийн нөхцөлийг бүрдүүлж өгөх явдал чухал анхаарах асуудал юм.

Түлхүүр үгс:

Техник технологи, чанартай боловсрол, хамтын ажиллагаа, сургалтын орчин

Оршил

Багш өөрийгөө хөгжүүлэх, мэргэжлээ дээшлүүлэх үйл ажиллагаа нь насан туршид нь үргэлжилдэг ба олон арга хэлбэрээр өөрийгөө тасралтгүй хөгжүүлж байдаг.

Багш хүн бие дааж уншиж судалдаг, Өөрийнхөө суурь мэдрэмжүүдийг хөгжүүлдэг, Сурган хүмүүжүүлэх сэтгэлгээ, сурган хүмүүжүүлэх ажилдаа хандах хандлага, харилцаа зэрэгтээ үнэлгээ дүгнэлт хийж, өөрийгөө өөрчилж, шинэчилж байдаг, Өөрийнхөө өдөр тутмын үйл ажиллагаандаа дүгнэлт хийж, сурган хүмүүжүүлэх тэмдэглэл хөтөлж байдаг. Сурган хүмүүжүүлэх судалгааны арга зүйг эзэмшиж, үйл ажиллагаандаа бүтээлчээр хэрэглэдэг. Ингэж Багшийг мэргэжлээрээ бүтээлч тасралтгүй ажиллах бүх хүч нөөцөө сургалтын ажилдаа зориулахад нь эдийн засаг, нийгмийн нөхцөлийг бүрдүүлж өгөх явдал маш чухал асуудал болж тавигдаж байна. Багийн багш нарын техник

технологийн хүртээмжийг нэмэгдүүлэх, багшийн ажлыг үнэлэх шалгуурыг нөхцөл байдалд нь уялдуулан бодитойгоор үнэлэх, хөдөө, багийн бага сургуульд ажиллаж байгаа багш нарт шинэ мэдээллийг хурдан түгээх, урамшуулах, бусад сургуулийн багш нартай туршлага солилцох, багш нарын нийгмийн баталгаа, хангамжийг сайжруулах гэх мэтээр цаашид олон хувилбартай хүртээмжтэй ажлуудыг зохион байгуулах шаардлагатай байна.

Судалгааны арга зүй:

Бид судалгаандаа нээлттэй асуулгыг урьдчилан бэлдэж, ажиглалтын болон фокус бүлгээр ярилцах, харьцуулан жиших аргатай хослуулан судалгааны ажлыг хийлээ

Зорилго:

Аймгийн төвийн, сумдын болон багийн бага сургуулийн багш нар ажлын байрандаа өөрийгөө хэрхэн хөгжүүлж байгаа, цаашид хэрхэн яаж хөгжих арга замууд байж болохыг тодруулах

Зорилт:

1. Багшийн хөгжлийн өнөөгийн байдлын судалгаа шинжилгээ хийх
2. Багшийн хөгжилд нөлөөлж буй хүчин зүйлсийн талаарх судалгаа
3. Багшийн ажлын байранд хөгжих үйл ажиллагааг сайжруулах арга замыг тодорхойлох

Үндсэн хэсэг

Багш өөрийгөө хөгжүүлэх, мэргэжлээ дээшлүүлэх үйл ажиллагаа нь насан туршид нь үргэлжилдэг ба олон арга хэлбэрээр өөрийгөө тасралтгүй хөгжүүлж байдаг.

Багшийн хөгжилд чухал нөлөө үзүүлдэг эерэг болон сөрөг хүчин зүйлсүүд

Хүснэгт 1.

№	Эерэг нөлөө	Сөрөг нөлөө
1.	Удирдлага хамт олны найрсаг харилцаа, хөгжлийг дэмжсэн орчин	Удирдлагын дарамт, хамт олны эрүүл бус харилцаа, багш хөгжих цаггүй байх
2.	Ажлыг нь шударгаар үнэн зөв үнэлж дүгнэн урамшуулах	Ажлыг шударга бус үнэлэх ба багшийн хийсэн ажилд итгэлгүй хандах, ажиллах урмыг хугалах, шударга бус өрсөлдөөн
3.	Олон нийтийн болон сонирхлын бүлгүүдийн хамтын ажиллагаа	Нийгмийн болон үйлчлүүлэгчдийн хэрэгцээний өөрчлөлтийг мэдрэхгүй байх


4. Үйлчлүүлэгч суралцагчид болон эцэг эхийн эерэг харилцаа	Нэр төр хөөцөлдөх, хэт их бичиг баримт цаастай зууралдах
5. Суралцагч байгууллага болох үзэл баримтлалыг хэрэгжүүлэх	Хуучин арга барил сэтгэлгээнээс салж чадахгүй байх, хэлбэрдэх
6. Заах аргын нэгдэл, секцийн ажил тогтмол чанартай явагдах	Суралцагчдад үйлчлэх үйлчилгээний чанарт анхаарахгүй байх

Судалгааны үр дүн -I

Багш ажлын байран дээрээ хөгжихөд тулгамдаж буй бэрхшээлүүдийн талаархи нээлттэй асуулгад аймгийн төвийн, сумын төвийн, багийн сургуулийн нийт 210 багш нар хамрагдсан.

1.1.Багийн сургуулийн 10 багшаас авсан Багш ажлын байран дээрээ хөгжихөд тулгамдаж буй бэрхшээлүүдийн талаархи судалгаа

Зураг 1.




Багийн сургуулийн багш нар мэргэжил, соёл, нийгэмд хандах хандлага, тэдний ахуй орчин, гарын авлага ховор, мэдээллийг цаг тухайд нь хүлээн авч чаддаггүй байна.

1.2. Сумдын Багш ажлын байран дээрээ хөгжихөд тулгамдаж буй бэрхшээлүүдийн талаархи нээлттэй асуулгад Сумдын сургуулийн 100 багш нар хамрагдсан.

1.2. Сумдын Багш ажлын байран дээрээ хөгжихөд тулгамдаж буй бэрхшээлүүд

Зураг 2.




Дээрх хариултаас харахад сумдын сургуулийн багш нар мэргэжил нэгт багш нар ховор, хамтран ажиллах гэхээр хамт олны уур амьсгал муу гэж хариулсанаас гадна мөн л багийн сургуулийн багш нарын адил цалин бага, ном, гарын авлага хомс гэх мэтээр судалгаанд хариулсан байна.

1.3. Аймгийн төвийн Багш ажлын байран дээрээ хөгжихөд тулгамдаж буй бэрхшээлүүдийн талаархи нээлттэй асуулгад аймгийн төвийн сургуулийн нийт 100 багш нар хамрагдав.

1.3. Аймгийн төвийн Багш ажлын байран дээрээ хөгжихөд тулгамдаж буй бэрхшээлүүд

Зураг 3.



Энэ хариултаас харахад аймгийн төвийн багш нар маань хууль эрх зүйн боловсрол орхигддог, ядаргаанд амархан ордог гэхээс гадна мөн л багийн болон сумын төвийн багш нарын адил ном, гарын авлага ховор, цалин бага, интернэт гэх зэргээр хариулсан байна.


Судалгааны үр дүн -II

Дээрх судалгаанаас үүдэн бид дараах судалгааг авлаа. Энэхүү судалгаа нь багш нар мэдээлэл харилцааны технологийг сургалтандаа хэрхэн ашиглаж байгаа эсэх асуудлыг тодруулахын тулд аймгийн төвийн 100 багш, сумдын сургуулийн 100 багш, багийн төвийн 10 багшаас судалгаа авч үзлээ.

Аймаг, сум, багийн багш тус бүрийг 100 % гэж үзвэл аймгийн сургуулийн багш нараас авсан судалгааны 88% нь МХТ-ийг сургалтандаа ашигладаг, сумын төвийн багш нарын 52 % нь, багийн сургуулийн багш нарын дөнгөж 10 % нь л ашигладаг гэсэн хариултыг өгсөн байна.

2.1. МХТ-ийг сургалтандаа ашигладаг байдлын талаархи судалгаа

Зураг 4.



Аймаг, сумын багш нар маань мэдээлэл харилцааны технологийг сургалтандаа хэрэглэх арга зүйг сайн эзэмшсэн байхад хөдөөгийн багш нар маань мэдээллээр бүрэн хангагдаж чаддаггүй ба ялангуяа багийн сургуульд ажиллаж байгаа багш нарт энэ асуудал нэн тулгамдсан асуудал болж байна.

Санал

Энэхүү судалгааг хийж байх явцад багш ажлын байран дээрээ хөгжихөд эрүүл мэндийн асуудал, цалин нь амьдралд хүрэлцэхгүй байх, ном, гарын авлага ховор зэрэг бэрхшээлүүд тулгарч байдаг. Эдгээр тулгарсан бэрхшээлээс гарахын тулд багш нар цалингийн зээл авч байна. Энэ нь багш нарт сэтгэл зүйн болон эдийн засгийн хүндрэл үүсгэж байна. Багшийн ажлын онцлог буюу хэт их чимээ шуугиантай нөхцөлд ажилласнаар эрүүл мэндийн асуудал тулгарч байна.

Дүгнэлт

1. Багшийн хөгжил зөвхөн багшаас шалтгаалах төдийгүй эдийн засаг, нийгмийн нөхцөлийг бүрдүүлж өгөх явдал хамгийн тулгамдсан асуудал болж байна. Аймгийн төвийн багш нар интернэтийн хурд удаан гэсэн байхад сумдын багш нар интернэт байхгүй, харин багийн бага сургуулийн багш нар гэрэл, цахилгаан байхгүй гэж судалгаанд хариулжээ.

2. Аймгийн сургуулийн багш нараас авсан судалгааны 88% МХТ-ийг сургалтандаа ашигладаг, сумын төвийн багш нарын 52%, багийн сургуулийн багш нарын дөнгөж 10 % МХТ-ийг ашигладаг байна.

3. Багшийн ажлыг үнэлэх шалгуурыг монголын орны нөхцөлд ойртуулан бодитойгоор үнэлэх, шинэ мэдээллийг хурдан түгээх, урамшуулах, туршлага солилцох, нийгмийн баталгаа, хангамжийг сайжруулах гэх мэтээр цаашид олон хувилбартай хүртээмжтэй ажлуудыг зохион байгуулах шаардлагатай байна.

WAYS OF TEACHERS TO DEVELOPMENT IN THEIR WORK PLACE

Abstract

Teachers face with new demands on their training due to developing society. They need to search new ideas and new ways. People from all parts of the world communicate with each other and get information with the help of television, radio, and the internet (chatting on the messenger, sending e-mails and making phone and video calls). Development is running very rapidly in any branches. It is expressing that we are in the era where teachers need to improve their knowledge continuously. Improving knowledge continuously is useful and important for their self-development. In this article, we discussed some ways of teacher's development in the work place.

Талархал

Энэхүү судалгааг хийхэд судалгаанд үнэн зөв хариулж, илэн далангүй ярилцаж, чин сэтгэлээсээ хандсан аймаг, сум, багийн ЕБС-ийн багш нартаа болон бүтээлээс нь ишлэл авсан багш Ш.Ичинхорлоо, Ч.Пүрэвдорж, Ч.Байгалмаа, С.Эрдэнэцэцэг нартаа талархал илэрхийлье.

Зохиогчийн тухай

Л.Цэрэннадмид нь 2005 онд Архангайн Багшийн сургуулийг бага ангийн багш мэргэжлээр, 2010 онд Соёлын дээд сургуулийг дуу хөгжмийн багш мэргэжлээр тус тус төгссөн. 2011 онд МУБИС-д “Бага ангийн сурагчдыг багш нар сэдэлжүүлж буй байдалд дүн шинжилгээ хийсэн нь” сэдвээр боловсрол судлалын магистрын зэрэг хамгаалсан. 2011 оноос МУБИС-ийн Архангайн Багшийн сургуульд дуу хөгжмийн багшаар ажиллаж байна. Архангайн Багшийн сургуулийн эрдэм шинжилгээний бичигт, МУБИС-ийн олон улсын эрдэм шинжилгээний бичигт, МУИС-ийн Орхон сургуулийн эрдэм шинжилгээний бичигт, Боловсрол судлал сэтгүүлд, Их дээд сургуулийн эрдэм шинжилгээний бичигт өгүүллүүдийг тус тус хэвлүүлсэн.

Ном зүй

1. Байгальмаа, Ч. (2009, 21-р тал). Багшийн хөгжлийн практик. Улаанбаатар
2. Ичинхорлоо, Ш. (2006). Багшийн хөгжил. Улаанбаатар
3. Ичинхорлоо, Ш. (2006). Багшийн ном. Улаанбаатар
4. Пүрэвдорж, Ч. (2011) Багшлахуйн менежмент. Улаанбаатар
5. Эрдэнэцэцэг, С, Ичинхорлоо, Ш. ба бусад, (2010) Багш боловсролын үндэс” Улаанбаатар